



МАСКАА ЗҮҮЕ



ГАРАА УГААЯ



ЗАЙГАА БАРЬЯ



УСНЫ САЛБАРЫН ЭРГЭН ТОЙРОНД



MILLENNIUM
CHALLENGE CORPORATION
UNITED STATES OF AMERICA

Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№2 (03)

2021.01.18

УСНЫ ТӨЛБӨРИЙГ ТЭГЛЭСЭН Ч ХЭРЭГЛЭЭНИЙ АЛДАГДАЛ ГАРААГҮЙ МӨН ХЭРЭГЛЭЭ НЭМЭГДЭЭГҮЙ БАЙНА



Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12-р сарын 13-ны өдрийн 211 тоот тогтоолоор айл өрхийн болон зарим үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрийг төрөөс хариуцах шийдвэр гаргасантай холбогдуулан Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Цогтсайхан, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь нар сэтгүүлчдэд мэдээлэл өгөв. Засгийн газрын шийдвэртэй холбогдуулан БХБЯ-аас гаргасан түр журамд хэрэглээ нэмэгдсэнээс үүдэн ус хангамж, ариутга татуургын ашиглалт, үйлчилгээний байгууллагын ачаалал зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд нийтийн эрх ашиг, аюулгүй байдлын үүднээс хэрэглэгчийн ус хангамжийг хязгаарлах арга хэмжээ авч талаар заасныг дурдаад, усны төлбөрийг тэглэсэн ч одоогоор хэрэглээний алдагдал гараагүй, хэрэглээ нэмэгдээгүй хэмээн мэдээллээ.

[Эх сурвалж: wsrc.mn](http://wsrc.mn)

“НӨХӨН СЭРГЭЭЛТ-2024” АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ДӨРВӨН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ ГАРЧЭЭ



БОАЖ-ын дэд сайд Ц.Батбаяр Нөхөн сэргээлтийн чиглэлээр 2020 онд хийгдсэн томоохон ажлууд болон ирэх жилүүдэд хэрэгжүүлэх ажлуудын талаар мэдээлэл өглөө. Тус яамны зүгээс 2020 онд бусад яам, газартай хамтран зохион байгуулсан “Нөхөн сэргээлт 2020” арга хэмжээний хүрээнд уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч сүйдсэн газрын нийт хэмжээг шинэчлэн гаргасан бөгөөд 30 790.94 га газрыг нөхөн сэргээх шаардлагатайг тогтоожээ. Эх сурвалжийн мэдээлснээр, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд нийт 1135 аж ахуйн нэгж 17.761.0 тэрбум төгрөг байршуулсан бөгөөд 2020 онд анх удаа тус сангийн мөнгөнөөс 84 сая төгрөгөөр

Архангай аймгийн Цэнхэр суман дахь 40 га талбайн 10 га-д нь нөхөн сэргээлт хийсэн байна. Цаашид “Нөхөн сэргээлт 2024” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахаар Шадар сайд, БОАЖ-ын сайд, УУХҮ-ийн сайд болон Хууль зүй, дотоодын хэргийн сайдын хамтарсан тушаал гарчээ. Энэ хүрээнд 26 ажлын хийж гүйцэтгэж, нийт 8000 га газрыг нөхөн сэргээхээр төлөвлөсөн байна.

[Эх сурвалж: БОАЖЯ-ны албаны ёсны фэйсбүүк хуудас](#)

ҮЙЛДВЭР, АХУЙН НЭГЖҮҮДЭЭС ТЦБ-Д НИЙЛҮҮЛЖ БУЙ ХАЯГДАЛ УСНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ АСУУДЛЫГ ХӨНДЖЭЭ



Үйлдвэр, аж ахуйн нэгжүүд, тэр дундаа арьс, ширний үйлдвэрүүд их хэмжээний бохирдолтой хаягдал усыг Төв цэвэрлэх байгууламжид нийлүүлж буйн улмаас цэвэрлэх байгууламжид асар өндөр ачаалал үүсч байгаа бөгөөд улмаар дутуу цэвэрлэгдсэн ус байгаль орчин, Туул голд нийлүүлэгдэж, бохирдуулж буй талаар Зариг.мн мэдээллийн сайт сурвалжлан мэдээлжээ. Уг сурвалжлагаар арьс ширний болон бусад бохирдуулагч үйлдвэрүүдийг урьдчилан цэвэрлэх байгууламжтай болгох, Монгол улсын бохир усны стандартад нийцсэн усыг ТЦБ-д нийлүүлэх зэрэг холбогдох шаардлага, дүрэм журмыг мөрдүүлж ажиллах, хяналт шалгалтаа сайжруулах,

түүнчлэн арьс ширний үйлдвэрүүдийг Улаанбаатар хотоос нүүлгэх зэрэг холбогдох арга хэмжээг цаг алдалгүй авч ажиллах шаардлагатай байгаа талаар асуудал хөнджээ.

[Эх сурвалж: Зариг.мн](http://zarig.mn)

ДЭЛХИЙД

ТУРКИЙН ХАМГИЙН ТОМ ХОТ ИСТАНБУЛ 45 ХОНОГИЙН УСНЫ НӨӨЦТЭЙ БОЛЖЭЭ



Турк улсад сүүлийн арван жилд тохиогоогүй ган гачиг болж байгаагаас шалтгаалан томоохон хотууд нь усны нөөцгүй болох аюул тулгарчээ. Тухайлбал тус улсын хамгийн том хот болох 17 сая оршин суугчтай Истанбулд ердөө 45 хоногийн усны нөөц үлдээд байна. Нийслэл Анкара хотын захирагч Мансур Яваш тус хотын ус хуримтлуулах даланд 110 хоногийн нөөц үлдээд байгааг энэ сарын эхээр мэдэгдэж байжээ. Дараагийн том хотууд болох Измир, Бурса хотуудын даланд тус бүр 36, 24 хувийн усны нөөц үлдсэн байна. Турк бол жилд нэг хүнд 1,346 шоо метр ус оногддог, усны нөөц муутай орон юм. 1980-аад оноос хойш хэд хэдэн том ган болсон нь уур амьсгалын өөрчлөлтөөс гадна хүн амын өсөлт, аж үйлдвэржилттэй холбоотой

гэгддэг. Усны гачигдлаас салахын тулд нөөцийн далан олныг нэмж байгуулах хэрэгтэйг Истанбулын Бодлогын Төвийн мэргэжилтэн, доктор Акгюн Илхан ярьсан. Сакаря хотын ойролцоох Мелен голоос Истамбул хот руу ус татах шугам хоолойн барилга угсралтын төслийг яаралтай хэрэгжүүлж дуусгах шаардлагыг Истанбул хотын захиргаанаас Засгийн газар хүргүүлээд байгаа аж.

[Эх сурвалж: ikon.mn](http://ikon.mn), balkaninsight.com